



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 11/51

Шивээговь сум

Тамхи худалдан борлуулах тусгай  
зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.4 дэх заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 86 дугаар тогтоол “Сумын нутаг дэвсгэрт тамхины худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ын 2.1, 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 1 дүгээр багт байрлах Шивээ Сервис ХХК-ийн супермаркет дэлгүүрийн тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийг 2021 оны 03 дугаар сарын 29-ний өдрөөс 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл 2 жилийн хугацаатай олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн хураамж болох 250000 /хоёр зуун тавин мянга/ төгрөгийг Орон нутгийн орлогод төвлөрүүлж, хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн /Б.Энхмаа/-д үүрэг болгосугай.

3. “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” болон “Тамхины хяналтын тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийг мөрдөж ажиллахыг Шивээ Сервис ХХК-ийн захирал /Ж.Чинбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ

42121-378